

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨР, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2008 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 307/91/2837

Улаанбаатар хот

**Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн
ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг
тооцож олгох журам батлах тухай**


Хөдөлмөрийн тухай хуулийн 48.2, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуулийн 12 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн батлах нь:

1. "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам"-ыг хавсралтын ёсоор батлах тухай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, үлэхийг төсвийн ерөнхий менежер нарт даалгасугай.
3. Шинжлэх ухаан, боловсрол, Хүн амын бодлого, хөдөлмөр, Сангийн сайдын хамтарсан 1995 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн "Журам батлах тухай" 126/97/114 тоот тушаалыг энэхүү тушаал батлагдсан өдрөөс, 2003 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн "Журам батлах тухай" 328/131/283 дугаар тушаалыг 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болсонд тус тус тооцсугай.

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД
Ө.ЭНХТҮВШИН

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД
Д.ДЭМБЭРЭЛ

САНГИЙН САЙД
Н.БАЯРТСАЙХАН



Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш (цаашид "сургууль, цэцэрлэгийн багш" гэх)-аар сургалт, хүмүүжлийн ажил гүйцэтгүүлэх, багш ба сургуулийн захирал, орлогч захирал, сургалтын менежер, хичээлийн зохицуулагч, дүрмийн ажилтан дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, ахлах багш (цаашид "зарим албан тушаалтан" гэх.)-ны цалин хөлсийг тооцож олгоход энэхүү журмыг баримтална.

2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан сургалтын төлөвлөгөө, Засгийн газраас тогтоосон бага, дунд боловсролын ажил, нормативыг үндэслэн тухайн хичээлийн жилд ажиллах багшийн орон тоог тогтоох заримал, эрхлэгч тогтооно.

3. Сургууль, цэцэрлэгийн багшийн ажил нь Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд заасан багшийн үүргийн хүрээнд багшийн ажлын байрны тодорхойлолтоор тодорхойлогдоно.

4. Анги дүүргэлтийг бага ангид 30-35 (багийн салбар бүлэгт 20-оос доошгүй) хүүхэд, ахлах ангид 32-35, ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийн багшийн дүрмийн дүүргэлтийг 25-30, харах сонсох эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 8-12, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 10-15 хүүхэдтэй байхаар зохион байгуулна.

5. Гадаад хэл, мэдээлэл зүйн хичээлийг мэргэжлийн багшийн хүрэлцээ, сургуулийн цалингийн сангийн хэмжээ, материаллаг орчин нөхцлийг харгалзан дэд бүжгээр хичээллүүлж болно.

6. Сургуулийн захиргаа нь багштай хөдөлмөрийн гэрээ байгуулж, Төрийн захиргааны зөвлөл болон Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журам, дүрмийн дагуу багшийн ажлыг үнэлж дүгнэх журам баримтлуулан мөрдөнө.

Хоёр. Багшийн ажлын бүтэц, норм

7. Сургууль, цэцэрлэгийн багшийн ажил нь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэх ажил болон бусад ажил гэсэн үндсэн хоёр үйл ажиллагаатай байна.

8. Стандартыг хэрэгжүүлэх ажил нь сургалтын хөтөлбөр (киррикулим) төвлөн боловсруулах, сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл заах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх гэсэн 3 үе шатны үйл ажиллагаанаас бүрдэнэ.

9. Бусад ажилд сургалтын үйл ажиллагааг дэмжих, багшийн хөгжлийг хангах, суралцагчидтай ажиллах гэсэн 3 төрлийн үйл ажиллагаа багтана.

10. Сургууль, цэцэрлэгийн багшийн долоо хоногийн ажлын цаг 40 байна.

11. Сургуулийн багш долоо хоногт 34 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ажил, 6 цагтай тэнцэх бусад ажлыг тус тус гүйцэтгэнэ. Стандартыг хэрэгжүүлэх ажилд ногдох 34 цагийн 19 цаг нь хичээл заах цагт зориулагдана.

12. Цэцэрлэгийн багш нь долоо хоногт ажлын 40 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлэх ба бусад ажлыг гүйцэтгэнэ.

13. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөний 1 цаг буюу нэг цагт зориулсан 40 минутыг ажлын 1 цагаар тооцно. Энэ хугацаа бага сургуулийн нэг хоёрдугаар ангид 35 минут байна.

14. Бага, дунд боловсролын стандартад нийцүүлэн сургалтын төлөвлөгөөний дагуу хөтөлбөрөө төлөвлөн боловсруулах, уг хөтөлбөрөөр хичээл заах, түүнийгээ хэрэгжүүлж сайжруулах цогц үйл ажиллагааг илэрхийлэх стандартыг хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг сургалтын нэгж ажлаар хэмжинэ. Энэхүү нэгж ажил нь сургалтын төлөвлөгөөний 5 цагаар тооцогдоно. Сургалтын нэгж ажлыг ерөнхий боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан гүйцэтгэл ажлын гачлалын дагуу тооцож үнэлнэ.

15. Сургуулийн сургалтын менежер нь стандартыг хэрэгжүүлэх болон багшийн ажлын гүйцэтгэлийг сар, улирлаар тооцож, сургуулийн захирлаар батлуулж үнэлж хүүд өгнө. Багшийн ажлын улирлаар гаргасан гүйцэтгэлийг багш нарын ажлын гүйцэтгэлийн хурлаар хэлэлцсэний дараа сургуулийн захирал батална.

Гурав. Цалин хөлс олгох

16. Сургууль, цэцэрлэгийн багш, зарим албан тушаалтны цалин хөлс нь албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал, урамшууллаас тус тус бүрдэнэ. Албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсний хэмжээ нь ерөнхий боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин хөлстэй харьцуулж тооцож, холбогдох Засгийн газраас баталсан тогтоолууд, холбогдох сайд нарын зарлигууд, баталсан тушаал, байгууллагын дотоод журам болон хамтын гэрээ, хэлэлцээрээр тооцогдоно.

17. Сургууль, цэцэрлэгийн багшийн нэмэгдэл нь багшийн мэргэжлийн болон ажил орны зэргийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, орон нутгийн нэмэгдлээс, зарим албан тушаалтны нэмэгдэл нь докторын зэргийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, орон нутгийн нэмэгдлээс тус тус бүрдэнэ.

18. Багшийн албан тушаалын үндсэн цалингаас тооцон Засгийн газрын тоолоор баталсан хувь хэмжээний дагуу ерөнхий боловсролын сургуулийн ажилтны зарлид анги даасны, Заах аргын нэгдэл удирдсаны, кабинет, лаборатори хариуцан ажилласны нэмэгдэл хөлс олгоно.

19. Багшийн албан тушаалын үндсэн цалингаас тооцон Засгийн газрын тоолоор баталсан хувь хэмжээний дагуу цэцэрлэгийн багшид Заах аргын нэгдэл рдаж ажилласаны нэмэгдэл хөлс олгоно

20. Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нь албан хаагч бүрийн өлмөрийн хөлсний хэмжээг холбогдох тогтоол, журам, албан хаагчийн ажлын үрнэ тодорхойлолт, үр дүнгийн гэрээний биелэлтийг үндэслэн тогтоож, багшын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн санал дүгнэлтийг тусгаж, тушаалаараа алгаажуулна.

21. Сум, дүүргийн Засаг дарга нь сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн өлмөрийн хөлсний хэмжээг холбогдох тогтоол, журам, тэдний ажлын байрны үрнэ тодорхойлолт, үр дүнгийн гэрээний биелэлтийг үндэслэн тогтоож, сургууль, цэцэрлэгийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал дүгнэлтийг тусгаж, тушаалаараа алгаажуулна.

22. Бага ангийн III-V ангийн англи хэл, мэдээлэл зүй, биеийн тамир, хөгжим, спортоор эрхлэх урлагийн хичээлийг мэргэжлийн багшаар заалгаж болно.

23. Мэргэжлийн багшийг үндсэн ажилтнаар ажиллуулах бололцоогүй нөхцөлд тэвэрт гарсан, сургуулийн бус байгууллагад ажиллаж байгаа болон ажилгүй байгаа мэргэжлийн багшийн үр чадварыг харгалзан хөлсөөр ажиллуулах гэрээгээр ажиллуулж, цагийн хөлсийг нь үндсэн багшийн цалин хөлсний хэмжээнээс хэтрэхгүй хурлаар тооцож олгож болно.

24. Багшийн илүү цагийг тооцохдоо 19 цагаас илүү заасан хичээлийн цагаар тооцно. Багшийг илүү цагаар ажиллуулсан бол Хөдөлмөрийн тухай хуулийн 53 дүгээр зүйлд заасны дагуу илүү цагийн хөлс олгоно (Жишээлбэл: Үндсэн цалинг/168 х 1.5 х 19 цагаас илүү заасан хичээлийн цаг).

25. Сурагчийн улирлын амралт болон онцгойлон хүндэтгэх шалтгаанаар өмнө өлмөрлөөгүй байсан хугацаанд багшид албан тушаалын үндсэн цалинг олгоно. Энэ хугацаанд багш өөрөө хүсвэл ээлжийн амралтаа урьдчилан эдэлж болно.

26. Сургуулийн мэргэжлийн сургалт, бусад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж бий болгосон бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний орлогоос үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахтай холбогдон гарах материаллаг зардлыг хасаад үлдэх хэсгээс зохих хэмжээгээр багш, сурагч, ажиллагчдад шагнал урамшуулал бодож олгоно.

27. Хичээлийн жилийн үргэлжлэх хугацааны бүтцийг үндэслэн багш, ажилтны ажлын амралтыг зохицуулна. Багш, ажилтны ээлжийн амралтын хугацааг өлмөрийн хууль, Боловсролын тухай хуулийг тус тус баримтлан тогтооно.

28. Багш нарын ээлжийн амралтын олговрыг холбогдох хууль, журамд зааснаар тооцож олгоно.